

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

№	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөн-гийн хэм-	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүн	Төсөв сая. төг	Төсвийн гүйцэтгэл сая. төг		
Зорилго: ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО												
Зорилго: 3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.												
Зорилт 3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.												
157	НЗДҮАХ 3.4.1.1.	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	114.6	Жуулчны мэдээллийн 4 төвөөс 4,000 хүн мэдээлэл авсан байна.	Мэдээллийн төвөөр 6.000 хүн мэдээлэл авсан байна.	114.6	114,6	Гадаад дотоодын жуулчдад мэдээлэл өгөх зорилгоор 2021 онд Жуулчны мэдээлэл, сурталчилгааны 4 төвөөс 4,000 хүн мэдээлэл авсан бол 2022 онд 6 төвөөр 15.000, 2023 онд байнгын ажиллагаатай 4, улирлын чанартай 3 нийт 7 төвөөр 10,741 гадаад, дотоодын иргэн. жуулчин үйлчилгээ авч, жуулчдын санал, хүсэлтийг хүлээн авах, зөвлөгөө, мэдээ мэдээллээр хангах лавлах 118 тусгай дугаарын утсаар 7500, жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн 70108687 утсаар 828, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Бүргэдийн баяр”, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” арга хэмжээ болон “Улаанбаатар травел экспо” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, “ITM Mongolia-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зэрэг арга хэмжээний үеэр жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн цэгийг ажиллуулж 30,000 нийт 49,069 гадаад, дотоодын иргэн, жуулчдад мэдээлэл зөвлөгөө өгч ажиллав.	100
158	НЗДҮАХ 3.4.1.2.	Улаанбаатар хотын онцлог	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	150.0	Аялал жуулчлалын чиглэ-	Аялал жуулчлалын чиг-	86,113, 2	86,113, 2	1. Улаанбаатарын өвлийн наадам-2023 арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 11,12-ны өдөр Скайрезорт цанын баазад зохион байгуулав. Арга хэмжээний үеэр Монгол туургатны аварга, улсын болон хотын аварга шалгаруулах тэмцээн зохион	100

		бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулч- лалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж шинэ аяллын бүтээг- дэхүүн, үйлчил- гээг нэвтрүүл нэ				лээр 10 үйл ажил- лагаа зохион байгуул- сан	лэлээр 14 үйл ажил- лагаа зохион байгуулж 60.000 хүн оролц- сон байна.	13,125, 0	13,125, 0	байгуулж хот хөдөөгийн 856 хүн оролцсон ба гадаад оролцогчдоос мөсөн сурын тэмцээнд ОХУ-ын Буриад, Тува, Халимаг улсаас 3 багийн 30, БНХАУ-ын ӨМӨЗО-с 1 багийн 10 нийт 40 гаруй тамирчид оролцлоо. Мөн чарга, цана, снөүбоард, параглайдинг, мөсөн хананд авирах, шувуулахуйн танин мэдэхүйн хөтөлбөр, нохой чарга, хоол ундны үйлчилгээг зохион байгуулж, нийт 10.000 гаруй гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. 2.Бүргэдийн баяр арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 04,05-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 08 дугаар хороо, Богд хан уулын Жаргалантын аманд байрлах “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. Арга хэмээний үеэр бүргэдчид үндэсний хувцсаараа гоён гаршуулсан бүргэдээ гарын шуун дээр суулгаж, бүргэдээр ан хийхэд тусгайлан сургасан морьтой жагсаал, хамгийн сайхан үндэсний хувцас, морь, бүргэдийн тоноглолтой шилдэг бүргэдчнийг шалгаруулав. Арга хэмжээг нийт 10.000 хүн үзэж сонирхсон. 3. Францын соёл аялал жуулчлалын өдөрлөгийг 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулж, арга хэмжээний үеэр СУИС-ийн оюутнууд хэлээр кармен дуурь, ЕБС-ын 1-р сургуулийн сурагчид Франц хэлээр хүүхдийн дууг олон нийтэд хүргэж, худалдаа үйлчилгээний чиглэлээр 40 аж ахуйн нэгж байгууллага хоол унд, бараа бүтээгдэхүүний танилцуулга хийж оролцов. 5000 хүн үзэж сонирхсон байна. 4. Дуу хөгжмийн бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг дэлхий нийтэд сурталчлах зорилгоор “Playtime” олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан “PRE-EVENT” арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулан 7 хамтлагийн 50 уран бүтээлч тоглолтоо хүргэж, арга хэмжээг нийт 1400 гаруй хүн үзсэн ба 07 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд “Монгол шилтгээн цогцолбор”-т 21 дэх удаагийн олон улсын “Плэйтайм-2023” хөгжмийн наадамд 170 гаруй хамтлагийн 1500 гаруй уран бүтээлч, дуучид 2 өдрийн турш уран бүтээлээ хүргэж арга хэмжээг 49,000 гаруй хүн үзэж сонирхов. Наадмын бэлтгэл
								16,672, 0		
								20,000, 0		

											<p>ажилд 3000 гаруй түр ажлын байр бий болгож, худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэлд 150 гаруй аж ахуй нэгжийн 600 гаруй ажилчин үйлчилгээ үзүүлэв.</p> <p>5. "Улаанбаатар травел экспо-2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг "2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулж 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон тур оператор компаниуд, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Манжуур хот, ОХУ-ын Буриад улсын аялал жуулчлалын нийт 180 байгууллага оролцож, нутаг, орныхоо байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газрын танилцуулга, амралт, рашаан сувиллын үнэ, байршил, хуваарь үйлчилгээний талаарх мэдээлэл, гадаад улс руу аялагчдад зориулсан аяллын хөтөлбөр, зөвлөгөө мэдээлэл өгч, үйл ажиллагаагаа сурталчилж оролцлоо. Арга хэмжээний үеэр аялагчдад зориулсан даатгал, түрээс, тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, аяллын клубүүд үйл ажиллагаагаа танилцуулав. Үзэсгэлэнг 7000 хүн үзэж сонирхов.</p> <p>6. "Тэнгэр" олон улсын бөөгийн фестивалийг 2023 оны 5 дугаар сарын 28-нд Чингис хааны хүрээ цогцолборт зохион байгуулж арга хэмжээнд БНСУ, Франц, Польш, АНУ, Канадын уугуул индиан, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриад зэрэг улсаас 40 гаруй бөө оролцож Нарны тахилга, Бөөгийн туг сүлд залах ёслол, Тэнгэрийн дуудлага зан үйл, Галын тахилга болон тухайн улсын бөө мөргөлийн онцлог, уламжлал, ёс заншлаас үзүүлж, морин цирк, уран нугаралт, рок попын тоглолт, байгаль дэлхийгээ хайрлаж, хог хаяхгүй байхыг уриалж, "Байгаль дэлхийгээ хайрлацгаая" хандивын аянг зохион байгууллаа. Арга хэмжээг нийт 10.000 хүн үзэж сонирхсон.</p> <p>7. "Монгол-Солонгосын аялал жуулчлалын тур операторуудын форум"-ыг 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж арга хэмжээний үеэр "Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, чиг хандлага", "Солонгос жуулчдын зан чанар, онцлог" сэдвүүдийн хүрээнд илтгэл, хэлэлцүүлэг, Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны танилцуулга, В2В уулзалт арга хэмжээ зохион байгуулагдаж, БНСУ-</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										<p>ын аялал жуулчлалын 90, Монгол Улсын 110 нийт 200 тур оператор компаниуд оролцов.</p> <p>8. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл” бий болгох ажлыг 2022 онд эхлүүлж 14 төрлийн 380 гаруй мод, бут тарьж суулгасан. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “Монгол-Солонгос”-ын аялал жуулчлалын тур операторуудын форумд оролцогч БНСУ-ын жижиг, дунд аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд, Монголын солонгос зах зээлийн тур операторын холбоо болон Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд “Цолмон трэвал” ХХК, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Жуулчин төгөл”-д мод тарих ажлыг 2023 оны 05 дугаар сарын 09, 27-ны өдрүүдэд зохион байгуулж улиас, монос, шинэс, нохойн хошуу, тэхийн шээг, хавилгана зэрэг нийт 8 төрлийн 230 гаруй мод тарих ажлыг үохион байгуулж “Жуулчин төгөл”-д нийт 18 төрлийн 510 мод тарьсан.</p> <p>9. “Хүрээ Энтертайнмент” ХХК-аас санаачлан орчин үеийн техникийн дэвшилтэт шийдэл Immersive projection mapping буюу 360 градусаар цацруулагч проектор дээр суурилсан дүрст үзүүлбэрийг Ардын язгуур урлагтай хослуулсан “Орижин” шоу тоглолтыг “White Rock Center”-т 2023 оны зуны турш зохион байгуулах нээлтийн арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж аялал жуулчлалын 80 гаруй тур оператор компани оролцлоо.</p> <p>10. Улаанбаатар хотыг ОХУ-д сурталчлах, тухайн улсаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын аяллын тухай танилцуулга, нэвтрүүлэг хийх ажлыг ОХУ-ын Красноярск хязгаарын Улсын телевизтэй хамтран 2023 оны 05 дугаар сарын 04-08-ний өдрүүдэд зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд ОХУ-ын Красноярск хязгаарын Улсын телевизийн мэдээний албаны найруулагч, хөтлөгч Владимир Богомоллов, зураглаач Федотко Дмитри нар Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Хустайн нурууны байгалийн цогцолборт газар, Чингис хааны хөшөөт цогцолбор, Чингис хааны Үндэсний музей, Зайсан толгой-зөвлөлтийн дайчдын хөшөө, Бурхан</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										176,52 0,0	<p>16. Монголчуудын уламжлалт өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Даншиг наадам-Хүрээ цам 2023” наадмыг 8 дугаар сарын 05,06 -ны өдрүүдэд Хүй долоон хутагт зохион байгуулсан. Наадмын үндсэн хөтөлбөрт Үндэсний бөхийн 256, буриадын бөхийн 64, Өвөр Монгол 64 бөхийн барилдаан, Жороо морь, Хязаалан, Их насны морьдын уралдаан, Үндэсний сур харвааны тэмцээн, Морьт харвааны тэмцээн, Сээр шалгах тэмцээн, Уухай шагайн харвааны тойром, Цам харайх ёслол, лам нарын дунд ном хаялцах тэмцээн, Балин урлалын тэмцээн, Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа, Монгол үндэсний таван тансаг идээ цайны үзэсгэлэн, үндэсний хоол ундаа үйлдвэрлэгчдийн худалдаа зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, Даншиг наадмын үеэр “Нүүдэлчдийн Нийслэл” эрдэм шинжилгээний хурлыг анх удаа зохион байгуулж 9 орны 50 Монголч эрдэмтэд, судлаач, түүхчид Монгол улсын өнө эртний түүх, эрт дээр үеэс уламжлагдан ирсэн өв соёлын талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. Наадмын соёлын хотхонд “Хүрээ цам-Майдар” түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн, Монгол хувцасны үзүүлбэр, дүүргүүдийн иргэдийн Ардын урлагийн тоглолт, Монгол туургатан улсуудын урлаг соёлын тоглолтууд, залууст зориулсан “Сити оф номадс” шоу тоглолтуудыг зохион байгуулагдсан. Наадмын арга хэмжээг Монгол Улсад суугаа 24 элчин сайдын яамны 72 зочид төлөөлөгчид, дотоодын 50.000 гаруй иргэд, 3.700 орчим жуулчид үзэж сонирхсон.</p> <p>17. Монголын үндэсний хоол болон олон үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэд, жуулчдад сурталчлан таниулах “UB FOOD FESTIVAL-2023” арга хэмжээ 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд 9 дэх жилдээ зохион байгуулж ресторан, зоогийн газрын 40 байгууллага бүтээгдэхүүнээ сурталчилж, худалдаалж оролцлоо. Арга хэмжээний үеэр Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид, DJ, ковер дуучид, жааз хөгжим, амьд хөгжмийн хамтлагын тоглолт болж, оролцогчдын дунд орол</p>	81,650, 0
--	--	--	--	--	--	--	--	--	--	---------------	---	--------------

											улсын 102 морьт харваачид 4 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тодрууллаа. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд зохион байгуулж АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, Франц, Австрали, Өмнөд Африк, Канад, Унгар, Монгол зэрэг дэлхийн 19 орны 88 тамирчид мастер, насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үе гэсэн ангиллаар “Скермиш” буюу түрэг харваа, “Рэйд” буюу Ази харваа, “Тавер” буюу Унгар харваа, “Хантинг”, “Монгол бөмбөг намнаа” гэсэн 5 төрлөөр өрсөлдөж “ИНАА” буюу олон улсын морьт харвааны холбооны дүрмээр зохион байгуулагдаж нийт дүнгээр Франц улсын баг тамирчид тэргүүн байр, Монгол улсын баг тамирчид 2 дугаар байр, Казакстан улсын баг тамирчид 3 дугаар байр эзэлсэн. Арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, морин циркийн үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр зохион байгуулагдаж арга хэмжээг нийт 5000 гаруй хүн үзэж сонирхов. 2021 онд 11 арга хэмжээ зохион байгуулж, 45.0 хүн оролцсон бол 2022 онд 16 арга хэмжээ зохион байгуулж 523.750 хүн оролцсон байна. 2023 онд 20 арга хэмжээ зохион байгуулж 221.609 хүн оролцов.	
			2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	15.0	Улаанбаатар брэндийн шинэ бүтээгдэхүүн бий болгож, 3,500 бараа бүтээгдэхүүнийг худалдаанд гаргасан.	Улаанбаатар брэнд төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.	30.000.0	-	2021 онд 6 төрлийн бүтээгдэхүүн бий болгож 8200 ширхэгийг сурталчилгаанд тараасан бол 2022 онд 10 төрийн бүтээгдэхүүн бий болгосон. 2023 онд Улаанбаатар хотын брэнд төслийн хүрээнд “Визит Улаанбаатар” лого, уриа үгийг бий болгон батлуулав. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвөөр дамжуулан Визит Улаанбаатар брэнд бүтээгдэхүүнийг танилцуулж, борлуулалт хийх ажилд дэмжлэг үзүүлэн Голден гоби 1, Зүймэл гар урлал, даавуун урлал 1, Хөсөг брэнд 10, Сувинер хаус 5, зэрэг 4 байгууллалтын 17 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаанд гарган, сурталчилгааны танилцуулга сэтгүүлд байршуулан олон нийтэд түгээн ажиллав.	100%
159	НЗДҮАХ 3.4.1.3	Жуулчдын зорин очих	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	70.0	Төр хурагч Цэцээ	Шинээр 1 бүтээгдэхүүн	-	351.300.0	2021 онд 3 тохижилтын ажлын зураг төслийг батлуулж, 3 явган аяллын зам тохижуулав. Үүнд Их тэнгэрийн амны хадны зураг орчны тохижилтын ажлын зураг төсөл, Сүхбаатар дүүргийн 20-р хороо,	90%

		газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ					гүн хүртэлх явган аяллын чиглэлийг тохижуулсан.	нэмэгдүүлсэн байна.			Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш цогцолборын ажлын зураг, төсөл, Богдхан уулын Зайсан-Дугуй цагаан чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажлын зураг төслийг боловсруулж батлуулав. 2022 онд Их тэнгэрийн амны хадны зураг орчныг тохижуулж, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш цогцолборыг байгуулан авто машины зогсоол, гадна хашаа, ариун цэврийн байгууламж, мод бут суулгах зэрэг 2 тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/926 дугаар захирамжийн дагуу он дамжин хийгдэж 2023 оны байдлаар 400 мк2 явган хүний замын бетон зутгалтын ажил, 20 мк2 боловсон ариун цэврийн байгууламжийн цооног газарт булж, холболтын ажил хийсэн, атомашины зогсоолын хэсэгт хайрга дэвссэн, 420 мк2 төмөр хайс барьсан.	
Зорилт 3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацийг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.												
160	НЗДҮАХ 3.4.2.1.	Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад, дотоод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	60.0	Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж, 20,000 хүн үзсэн.	Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж, 40,000 хүн үзсэн байна.	-	46,315,3	1. 2023 онд Улаанбаатар өвлийн наадам, Бүргэдийн баяр, Талын салхи мото наадам, Дээлтэй Монгол наадам, Тэнгэр фестиваль, Францын соёл аялал жуулчлалын өдөр, "Даншиг наадам-Хүрээ цам" наадам, "УБ ФҮҮД" Фестиваль, " Улаанбаатар" Явган аяллын фестиваль, Солонгосын соёлын өдрүүд, Японы соёлын өдрүүд, Хийморь морьт харвааны ДАШТ зэрэг арга хэмжээнүүдэд богино хэмжээний контент хийж инстаграм, фэйсбүүк цахим орчинд байршуулсныг нийт 384 732 хүн үзсэн байна. 2. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, БНХАУ-аас зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Улаанбаатарын үдэш" дууг (хятад хэл) дуулж 250 сая гаруй хүнд хүргэсэн БНХАУ-ын "Чинхай" мужийн "Гүйнань" хотын ээж хүү хоёр уран бүтээлч Гензанг Жуама, Данжен нарыг урьж дууг дүрсжүүлэн олон нийтэд түгээж, зураг авалтыг 2023 оны 09 дүгээр сарын 09-20-ны өдрүүдэд зохион байгуулав. Дуучдыг Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө нар хүлээн авч уулзсан бөгөөд тэднийг Улаанбаатар хотод ирсэн тухай мэдээлэл	100%

											БНХАУ-ын цахим орчинд цацагдсан даруйд 60 сая гаруй хүнд хүрээд байна. 2021 онд Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж 20,000 хүн, 2022 онд аялал жуулчлалын 2 контент бэлтгэж 40,000 хүн үзсэн байна. 2023 онд 7 контент бүтээж дотоодын 384.732, гадаадын 60 сая хүн үзсэн байна.	
161	НЗДҮАХ 3.4.2.2.	Улаан-баатар хотыг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн-гүүдэд оролцож сурталчлан таниулна.	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	245.0	Нийт 4 олон улсын чанартай үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон	Олон улсын чанартай 7 үзэсгэлэнд оролцсон байна.	400.00 0.0	17,500, 0	1. ХБНГУ-ын Берлин хотод 2023 оны 03 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай Ти Би-Берлин” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд зочин оролцогчоор оролцсон. Үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар хотыг сурталчлах “Ulaanbaatar Your gateway” сурталчилгааны сэтгүүл 300 ширхгийг тараан, олон улсын байгууллагууд, аж ауй нэгжүүдэд мэдээлэл өгч ажиллав. 2. Монгол-Хятад хоёр улсын аялал жуулчлалын зөвлөлийн уулзалт 2023 оны 04 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод зохион байгуулагдав. Уулзалтад Нийслэлийн Аялал жуулчлалын газар, тур оператор компаниуд, “Хүннү эйр” компанийн төлөөлөл оролцлоо. Арга хэмээний үеэр Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улсын томоохон арга хэмжээний танилцуулга хийж, Манжуур хотоос тусгай сонирхлын жуулчид хүлээн авах талаар ярилцаж, тур оператор компаниуд, Манжуур хотын тур оператор компаниудтай B2B уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах гэрээ байгуулав. 3. БНСУ-ын Сөүл хотноо 2023 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд “Сөүлийн олон улсын аялал жуулчлалын экспо” үзэсгэлэн зохион байгуулагдав. Үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал Жуулчлалын Холбоо болон Let’s Travel, UVS, Paryca тур, Mongolian vision tours, Authentic Tours, Birgatour, Great Mongolia Tour, Zaya Travel ХХК зэрэг тур оператор компаниуд хамтран Монгол улс, Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээлэл өгч, үндэсний урлагын тоглолтоос үзүүлж сурталчилгаа хийв. Үзэсгэлэн нь Ази тив дэх хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн бөгөөд үзэсгэлэнд 100 гаруй орны 50,000 гаруй оролцогчид хамрагдан аялал жуулчлалын бүтээгдэхүүн,	100%

										44,380, 4	үйлчилгээгээ сурталчлав. Үзэсгэлэнгийн үеэр “Аялал жуулчлалын салбарын сэргэлт, дижитал шилжилт, инноваци ба аялал жуулчлалын өсөлт” сэдвийн хүрээнд форум, хэлэлцүүлэг зохион байгуулагдаж 13 орны 500 зочид төлөөлөгчид оролцсон. 4. “Монголд зочлох жил 2023-2025” арга хэмжээний хүрээнд хөрш орнуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх, 2023 онд Оросын Холбооны Улсаас 200-250 мянган жуулчин хүлээн авах зорилгоор Монгол-Оросын тур оператор компаниудын форум уулзалт, танилцах аяллыг 2023 оны 02 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Форумд Оросын Холбооны Улсын 27 бүс нутгаас 100 тур оператор компани, 35 хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл, Монгол Улсаас 106 тур оператор компаниуд оролцож, нийт 200 гаруй төлөөлөгчдийн дунд бизнесийн гэрээ хэлцэл хийх, харилцан мэдээлэл солилцох B2B уулзалт зохион байгуулагдлаа.	
										47,801, 3	5. БНСУ-аас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ, БНСУ-ын жижиг, дунд аялал жуулчлалын холбоо, Монголын солонгосын зах зээлийн аялал жуулчлалын холбоотой хамтран “Монгол-Солонгосын аялал жуулчлалын тур операторуудын форум”-ыг 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Монгол-Солонгосын аялал жуулчлалын тур операторуудын форумд БНСУ-ын аялал жуулчлалын 90 тур оператор компани, Монгол Улсын 110 тур оператор компани нийт 200 тур оператор компаниуд оролцож, B2B уулзалт зохион байгууллаа. Форумын үеэр “Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, чиг хандлага”, “Солонгос жуулчдын зан чанар, онцлог” сэдвүүдийн хүрээнд илтгэл, хэлэлцүүлэг явагдаж, нийслэлийн Аялал жуулчлалын газраас Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны видео танилцуулга хийлээ.	
										-	6. “Улаанбаатар травэл экспо-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны гишүүн муж, аймаг, хотуудын уулзалтыг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “IBIS” зочид буудлын	

										<p>хурлын танхид зохион байгуулав. Уулзалтад БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёл, аялал жуулчлалын танхимын орлогч дарга Жан Вэнь Жүнь, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Аялал жуулчлалын сайд Д.А.Жангарович, Манжуур хотын Засаг даргын орлогч Гө Шяофан, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Т.Мөнх-Од, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Төв зэрэг гишүүн аймгуудын төлөөлөл болон Монгол Улс, БНХАУ, ОХУ-ны аялал жуулчлалын тур оператор компани, бизнес эрхлэгчдийн нийт 70 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон.</p> <p>7. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран "Улаанбаатар травел экспо-2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд 9 дэх жилдээ зохион байгуулав. Үзэсгэлэнгийн нээлтэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёл, аялал жуулчлалын танхимын орлогч дарга Жан Вэнь Жүнь, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Аялал жуулчлалын сайд Д.А.Жангарович нар оролцлоо. Үзэсгэлэнгийн үеэр жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг ажиллуулж "Монгол-олле" явган аяллын маршрут, "Visit ulaanbaatar" брэнд бүтээгдэхүүн, Улаанбаатар хотын автобустай аялал болон 2023 онд зохион байгуулагдах эвент арга хэмжээнүүдийн талаар танилцуулж, 4 төрлийн 1000 ширхэг Улаанбаатар хотын сурталчилгааны материал тараан 1500 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгч үйл ажиллагаа. Мөн цайны замын дагуу Монгол Улс, БНХАУ, ОХУ-ыг холбосон маршрутаар авто, мото аялал болон хүүхдийн аялал зохион байгуулах, аяллын шинэ брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор 3 улсын 12 тур оператор компани хамтран ажиллах гэрээ байгуулав.</p> <p>8. БНХАУ-ын Чанша хотноо 2023 оны 05-р сарын 08-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн хотуудын Аялал жуулчлалын холбооны дарга нарын дээд хэмжээний уулзалтад Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөө, Нийслэлийн</p>	35,945, 8
--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--------------

										6,620,0	<p>Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар оролцов. Арга хэмжээнд БНХАУ-д суугаа 8 улсын Элчин сайд, WTСF-ийн гишүүн хотуудын 37 улсын аялал жуулчлалын томоохон аж ахуйн нэгжүүдийн 400 гаруй төлөөлөгчид оролцсон. Уулзалт арга хэмжээний үеэр Улаанбаатар хот Дэлхийн хотуудын Аялал жуулчлалын холбооны 156 дахь гишүүн болж. Батламжаа гардан авч, шинэ гишүүн хотуудыг төлөөлж Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөө үг хэллээ. Уг холбоонд элссэнээр Улаанбаатар хотыг гадаад, дотоодод сурталчлах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоход томоохон хөшүүрэг болох юм. Уулзалтаар Аялал жуулчлалын сэргэлт, Сорилт ба хамтын ажиллагаа, Хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ аргачлал илтгэлүүд, 2023 оны аялал жуулчлалын эдийн засгийн чиг хандлага, Дэлхийн хотуудын Ковид цар тахлын нөхцөл дэх тогтвортой хөгжлийн тайланг хэлэлцэж, хөрөнгө оруулалтыг дэмжих хурал, В2В уулзалт зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. Арга хэмжээний үеэр цайны замын дагуу Монгол Улс, БНХАУ, ОХУ-ыг холбосон маршрутаар авто, мото аялал болон хүүхдийн аялал зохион байгуулах, аяллын шинэ брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор 3 улсын 12 тур оператор компани хамтран ажиллах гэрээ байгуулав.</p> <p>9. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод 2023 оны 09 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Цайны зам олон улсын соёл аялал жуулчлалын хуралд Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөө, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар оролцов. Хуралд БНХАУ-аас 200, ОХУ-аас 45, Монгол Улсаас 20 гаруй нийт 265 төлөөлөгчид оролцож Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх Улаанбаатар хотын аялал жуулчлалын талаар танилцуулж, авто аялал болон эвент арга хэмжээг зохион байгуулах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал солилцлоо. Мөн Монгол, БНХАУ, ОХУ гурван улс дамнасан Цайны зам аялал жуулчлалын брэндийг хөгжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд БНХАУ-</p>
										6.151.3 80	

											<p>ын ӨМӨЗО-ы Хөх хотын Засаг захиргааны Гадаад харилцааны албаны дарга Хоу Жихуй, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотын Намын байнгын хорооны гишүүн, хотын даргын орлогч Жанг Фифэйтэй тэргүүтэй хүмүүстэй албан уулзалт хийж “Жуулчин төгөл” төслийг хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.</p> <p>10. Япон Улсын Осака хотод "Ирээдүй хаалгыг нээцгээе" уриа дор “JATA-2023” (Tourism Expo Japan) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2023 оны 10 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж дэлхий 70 улсын 1275 аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгч нар оролцож үзэсгэлэнг 4 өдрийн турш нийт 148,050 хүн үзэж сонирхсон байна. Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам, Жайка олон улсын төслийн байгууллагын дэмжлэгтэйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “МИАТ” ХК болон “Juulchin”, “New Juulchin Tours”, “Lets travel”, “Shine zuuch travel”, “Jiguur”, “Iris tour”, “Best nomadic”, “Weyo travel”, “Jamo tour”, “Altantour”, “Amicus Travel Mongolia” зэрэг 14 тур оператор компани, Өмнөговь аймгийн “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбоо түүний харьяа 10 жуулчны бааз үзэсгэлэнд оролцож үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.</p> <p>2021 онд 3 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсон бол 2022 онд 8 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон байна. 2023 оны байдлаар 10 олон улсын үзэсгэлэн арга хэмжээнд оролцов.</p>	
										нийт 158,39 8,8		
Зорилт 3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.												
162	НЗДҮАХ 3.4.3.1.	Жуулч- дыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчи- лан сэргий-	2023	НАЖГ	Нийс- лэлийн төсөв	10.0	Жуулч- дын аюулгүй байдлыг хангах чиглэ- лээр зохион	Жуулч- дын аюулгүй байдлыг хангах чиглэ- лээр зохион	-	-	<p>1. Гадаад, дотоодын иргэд, жуулчид, аялал жуулчлалын байгууллагуудын санал хүсэлтийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Налайх дүүргийн 06 дугаар хороо, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт байрлах Зуун ламын агуй, Мэлхий хад, Арьяабал бурхан засалч, бясалгалын төв, Экстрим аялал ХХК, Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэр Цонжин болдогт байрлах “Чингис хааны хөшөөт цогцолбор”-ын үйл ажиллагаатай танилцаж, гадаад дотоодын иргэд,</p>	100%

		лэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ				байгуулсан арга хэмжээ 3 байна.	байгуулсан арга хэмжээ 4-г зохион байгуулсан байна.		<p>жуулчдыг ая тухтай, аюулгүй аялах нөхцөл боломжоор хангах, гадна, дотно цэвэрлэгээ, өнгө үзэмж, тохижилт үйлчилгээгээг сайжруулах, нүхэн жорлонг буулгах, стандартын дагуу ариутгал хийж булах, боловсон ариун цэврийн байгууламж байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, стандартын дагуу үйлчилгээ эрхлэх талаар заавар зөвлөмж өгч ажиллав.</p> <p>2. Нийслэлийн Аялал жуулчлалын газраас “Монголд зочлох жил”, “Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв”, Хотын стандарт, хяналтын газраас “Хотын стандартууд”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” сэдвээр сургалт зохион байгуулж, Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын 355 удирдлага хамрагдлаа.</p> <p>3. Гадаад дотоодын аялагч, жуулчдыг гэмт хэрэг, зөрчил, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Аюулгүй аялах зөвлөмж” контент бэлтгэн https://tourism.ub.gov.mn/ сайт, youtube цахим сүлжээнд байршуулан 212 хүн үзсэн байна.</p> <p>4. Гадаадын жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оюутан залуусыг түр ажлын байраар хангаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран “Оюутан цагдаа-2023” арга хэмжээг зохион байгуулав. Оюутан цагдаагаар ажиллах оюутнуудад хууль эрх зүй, Улаанбаатар хотын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, тараах Улаанбаатар хотын газрын зураг, аюулгүй аялах Санамжийг тайлбарлаж зөвлөгөө өгөх сургалтад нийт 90 оюутанг хамрууав. Оюутан цагдаа нар 3 сарын хугацаанд Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 5, зөрчлийн шинжтэй 17 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 7062, гадаадын 7666 иргэнд туслалцаа үзүүлж, 9 төрлийн 11680 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, 758 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж өгч, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 66 бага насны хүүхдийг ар гэрт нь, 1 хүүхдийг цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, монгол</p>
--	--	--	--	--	--	---------------------------------	---	--	--

											орны байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний газрын тухай 7 бүлэг 36 мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 6981 жуулчдад танилцуулж ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийг төвтэй хамтран жуулчид, гадаадын иргэдэд оюутан цагдаагийн үйлчилгээ таалагдсан, эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц мэдээллийг олон нийтийн сүлжээгээр 2153 түгээлт хийж, 14046 иргэн үзэж, 1510 сэтгэгдэл бичиж, 1 контент бүтээж, 4 телевиз, 15 сайтаар иргэд, олон нийтэд хүргэсэн байна. 2021 онд 2 арга хэмжээ зохион байгуулсан бол 2022 онд 4 арга хэмжээ зохион байгуулсан. 2023 оны байдлаар Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 4 арга хэмжээ зохион байгуулж ажиллав.	
163	НЗДҮАХ 3.4.3.2.	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	Нийслэл хотын албан татвараас 7.345.3 мянган төгрөг төвлөрсөн.	Нийслэл хотын албан татвараас нийслэлийн төсөвт 10.000.0 мянган төгрөг төвлөрсөн байна.	-	-	2020 онд 5,181,626.100 төгрөг 2021 онд 7.345.300.000 төгрөг 2022 онд 11.100.000.000 төгрөг 2023 оны 11 сарын байдлаар 12,736,167.100 төгрөг төвлөрүүлэв. Үр нөлөө: 2020-2023 оны байдлаар Нийслэл хотын албан татвараас нийт 36.363.093,200 төгрөг төсөвт төвлөрүүлэв.	90%

		холбож, нийслэл хотын албан татва- раас төвлөрөх орлогыг нэмэг- дүүлнэ									
164	НЗДҮАХ 3.4.3.3.	Салба- рын ажилт- нуудын ур чадва- рыг дээшлүү лэхэд чиглэсэн төрөлж- сөн сургал- туудыг зохион байгуул- на	2023	НАЖГ	Нийс- лэлийн төсөв	Хөтөч тайлбар лагч оюутан цагдаа зэрэг сургал- тад нийт 619 хүнийг хамруул сан сургалт зохион байгуул- сан.	Сургал- тад 450 хүн хамруул- сан байна.	20.0	19,500, 0	1. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Солонгос хэлний аяллын хөтөч-тайлбарлагч” бэлтгэх сургалтыг “Гайд” боловсролын төвтэй хамтран 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаатай зохион байгуулж 12 аяллын хөтөч хамрагдав. 2. Аяллын хөтөч тайлбарлагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Чингис хаан музейтэй хамтран “Чингис хаан музейд тайлбар хийх” эрх олгох сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 21-22, 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч 100 хүн хамруулж, Чингис хаан музейд 2023 оны турш тайлбар хийх эрхийн үнэмлэх олгов. 3. Нийслэлийн Аялал жуулчлалын газраас “Монголд зочлох жил”, “Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв”, Хотын стандарт, хяналтын газраас “Хотын стандартууд”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” сэдвээр сургалт зохион байгуулж, Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын 355 удирдлага хамрагдлаа. 4. Зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах комисстой хамтран наадмын үеэр хөтчөөр ажиллах сайн дурын ажилтнуудад “Хөтөч, тайлбарлагчдын соёл, ёс зүй, олон улсын стандарт” сэдвээр Гайд боловсролын төвийн захирал Ч.Буянбадрах, “Улаанбаатар хотын түүх соёл, хотын танилцуулга, түүхэн дурсгалт газар, гол үзмэрүүдэд тайлбар хийх нь” сэдвээр Улаанбаатар	100%

											<p>хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр, “Гадаадын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хууль эрх зүйн мэдлэг олгох” сэдвээр Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журмын хамгаалах газрын мэргэжил арга зүйн тасгийн ахлах байцаагч цагдаагийн хошууч Ч.Хадбаатар нар илтгэл тавьж, сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Иргэний танхимд зохион байгуулав. Сургалтад сайн дурын 50 ажилтан хамрагдлаа.</p> <p>5. Үйлчилгээний ажилтны ур чадварыг сайжруулах зорилгоор цахим сургалтын гарын авлага бэлтгэн youtube цахим сүлжээ, https://tourism.ub.gov.mn/ сайтад байршуулан “Угтах үйлчилгээ” хичээлийг 338, “Зөөгч”-ийн гарын авлага хичээлийг 437 хүн, “Өрөө үйлчилгээ” ажилтны гарын авлага хичээлийг 699, “Хөтөч тайлбарлагчийн анхан шатны мэдлэг олгох” хичээлийг 434, “Жуулчин тээвэр, такси үйлчилгээний ажилтнуудын харилцаа хандлага” хичээлийг 79, “Жуулчидтай харилцдаг төрийн албан хаагчдын харилцаа хандлага” хичээлийг 135, нийт 6 төрлийн цахим сургалтын гарын авлага хичээлийг 2122 хүн үзсэн байна.</p> <p>6. Гадаадын жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оюутан залуусыг түр ажлын байраар хангаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран “Оюутан цагдаа-2023” арга хэмжээг зохион байгуулав. Оюутан цагдаагаар ажиллах оюутнуудад хууль эрх зүй, Улаанбаатар хотын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, тараах Улаанбаатар хотын газрын зураг, аюулгүй аялах Санамжийг тайлбарлаж зөвлөгөө өгөх сургалтад нийт 90 оюутанг хамрууав.</p> <p>7. Нийслэлийн Засаг даргын 2023 оны Үйлчилгээний ажилчдын гарын авлага бэлтгэж түгээх тухай А/718 дугаар захирмжийн дагуу Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, хотын соёлыг дэлгэрүүлэх, төрийн болон нийтийн үйлчилгээнд эерэг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх, найрсаг үйлчилгээг бий болгох, Хотын стандарт болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах, сурталчлах зорилгоор</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											<p>зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулсан 4 төрлийн контентийг Олон улсын аялал жуулчлалын сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж үйлчилгээний байгууллагуудад хүргүүлэв.</p> <p>8. БОАЖЯ-тай хамтран салбарын бодлого шийдвэр, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, зочид буудал, зочлох үйлчилгээний салбарын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын түвшинд хүргэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хоорондын уялдаа холбоог сайжруулах, төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ажлын үр дүнг дээшлүүлэх сургалт зохион байгуулж аймаг, нийслэл, дүүргийн 40 төрийн албан хаагчийг хамруулав.</p> <p>2021 онд 8 удаагийн сургалт зохион байгуулж 900 гаруй хүнийг хамруулсан бол 2022 онд 9 удаагийн сургалт зохион байгуулж 750 хүн хамруулсан. 2023 оны байдлаар нийт 8 удаагийн 17 төрлийн сургалтад 2769 хүн хамрагдсан байна.</p>	
Зорилт 3.4.4. “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.												
165	НЗДҮАХ 3.4.4.1.	“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж хэрэгжүүлнэ	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв		Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлого шаардлагатай	“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж хэрэгжүүлнэ		-	Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 7 зорилтын 77 арга хэмжээ 2023 оны байдлаар 70%-ийн хэрэгжилттэй байна.	70%
Зорилт 3.4.5. Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.												

166	НЗДҮАХ 3.4.5.1.	Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ	2023	НАЖГ	Нийслэлийн төсөв	Цар тахлын дараа Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц төлөвлөгөө шаардлагатай	Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ	-	-	Ковидын дараах нийслэлийн Аялал жуулчлалыг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө 5 зорилтын 27 арга хэмжээ 2023 оны байдлаар 70%-ийн хэрэгжилттэй байна.	70%
Нийт дүн									1,431,5 94,1	92%	

ТАНИЛЦСАН: ДАРГА



D. Babu

Д.БАТСҮХ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Shul

Д.ГАНБОЛД

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ,
СТАТИСТИК СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Chen

Ч.ЭНХ-ОТГОН - 2

D. Ouyun-Zorig

НЭГТГЭСЭН: БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГИЙН ТАЙЛАН, СУРГАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

M

Э.МӨНХЗУЛ